

БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ
ТУХАЙ ГЭРҮЭ

2018.оны 02.сарын 01.өдөр

Дугаар

Алтай сум

“Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 2.4, 3.1.3, 6.1.3-т заасны дагуу нэг талаас Төв-Улаанбаатар (хот)-ийн Алтайн . сум, (дүүрэг)-ын Засаг дарга Д.Чиратжанбек (цаашид “Засаг дарга” гэх), нөгөө талаас “Д.Чиратжанбек” нөхөрлөл, хоршоо, бүртгэгдээгүй нөхөрлөл (цаашид “Бичил уурхай эрхлэгч этгээд” гэх)-ийг төлөөлж Алтай .. (албан тушаан) З.Монголбаяр пар (цаашид хамтад нь “Талуул” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2018. оны 03. дугаар сарын 07.-ны өдөр энэхүү төрөөг (цаашид “Гэрээ” гэх) Алтай : сум (дүүрэг)-д байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Бичил уурхай эрхлэгч этгээд нь Алтай . сум (дүүрэг)-ийн Ч.М.Баг.Зодолж.оюу иортэй газарт орших . . 5,7... км гектар талбайд журмын 6.1.3-т заасны дагуу жилийн хугацаагаар . . 3- (ашигт малтмалын төрөл) олборлохтой холбогдсон үйл ажиллагаа эрхэлнэ.

1.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар сум (дүүрэг)-ын Засаг дарга, бичил уурхай эрхлэгч этгээдийн хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулиа.

Хоёр. Сум (дүүрэг)-ын Засаг даргын эрх, үүрэг

2.1. Сум (дүүрэг)-ын Засаг дарга нь “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 6 дугаар зүйлд зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. бичил уурхай эрхлэгч этгээдэд ногдох талбайн хэмжүүг тогтоож, байршилын зургийг гэрээнд хавсаргах

2.1.2. хог хаягдлын цэгийн байршлыг тогтоох

2.1.3. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу нөхөн сэргээлтийн зардлыг тооцож, бичил уурхай эрхлэгч этгээдтэй тохиролцсоны үндсэн дээр зохих хөрөнгийг төвлөрүүлэх;

2.1.4. бичил уурхайн ажилтнуудад (цаашид “ажилтан” гэх) зориулсан ходолмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтыг мэргэжлийн байгууллагын тусlamжтайгаар зохион байгуулах;

2.1.5. энэхүү горцэгээр хүлээсэн үүргээ биелүүлжийн бичил уурхай эрхлэгч этгээдээс шаардах;

2.1.6. байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн толовлогөөний гүйцэтгэлд хяналт тавих;

2.1.7. хүрээлэн байгаа орчинд сөрөг нолоолол үзүүлж байгаа үйл ажиллагааг зогсоох.

Гурав. Бичил уурхай эрхлэгч этгээдийн эрх, үүрэг

3.1 Бичил уурхай эрхлэгч этгээд дараах эрх, үүргийг хэрэгжүүлийн:

3.1.1. бичил уурхай эрхлэгч этгээдэд олгосон талбайд ашигт малтмал олборлох үйл ажиллагаагаа явуулах;

3.1.2. ажилтнуудыг тогтоосон талбайд суурьшуулах;

3.1.3. суурьшлын талбайг тохижуулж, ахуйн болон үйлдвэрийн хог, хаягдлын цэгийг байгуулах;

3.1.4. гэрээгээр олгосон талбайд нөхөрлөл, хоршоо, бүртгэгдээгүй нөхөрлөлийн гишүүн бус этгээдийг ажиллуулахгүй байх;

3.1.5. байгаль орчныг хамгаалж, гол, горхи, булаг шанд, уст цэгийг бохирдуулахгүй байх;

3.1.6. бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг дагаж мөрдох, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

3.1.7. хууль тогтоомж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон нөхөн сэргээлтийн чиглэлээр ажилтнуудад сургалт, сурталчилгаанд бичил уурхайчдыг идөвхтэй оролцуулах;

3.1.8. ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах үйл ажиллагааг тогтоосон талбайд гүйцэтгэх;

3.1.9. үйл ажиллагаандаа химийн хорт болон аюултай бодис хэрэглэхгүй байх, тусгай зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд тэсэрч дэлбэрэх бодис. тэсэлгээний хэрэгсэл алиглахгүй байх;

3.1.10. Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхрлөл, мөн хуулийн 36.4-т заасан хори^ж-фоны зохион байгуулалтад орсон бичил уурхай эрхлэгч этгээд нь ашигт малтгамал олборлох үйл ажиллагаанд 3500 см³ хүртэлх багтаамжтай дотоод шаталтат хололгүүр бүхий 2-оос илүүгүй механизмыг ашиглах;

3.1.11. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу эрх бүхий этгээдийн тогтоосон байгаль орчны нөхөн сэргээлтийн зардалд шаардагдах ~~300,000 төгр.~~
~~нэвтрүүлэхэд~~ / төгрөгийг нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлэх;

3.1.12. нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлсэн хөрөнгийг олборлолт явуулсан талбайн нөхөн сэргээлтэд зарцуулах;

3.1.13. ХХОАТ нөхөрлөл сард ~~300,000 төгрөгийг нэвтрүүлэхэд~~ төгрөг төлнө,

3.1.14. олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу худалдан авах эрх бүхий хуулийн этгээдэд худалдах;

Дөрөв. Харуул хамгаалалтын ажилтаны эрх үүрэг

4.1.1. Засаг даргатай гэрээ байгуулаагүй, нөхөрлөлийн бус этгээдийн бичил уурхайн сайтруу нэвтрүүлэхгүй байх,

4.1.2. Нөхөрлөлийн гишүүдийн амгалан тайван байдлыг хангаж ажиллана,

4.1.3. Нөхөрлөлийн гишүүдээс гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг шаардах,

4.1.4. Гэрээгээр орсон нөхөрлөлийн гишүүл, гишүүн бус хүи авч орох,,үнэмлэх дамжуулж ашиглах тал дээр хатуу анхаарч ажиллах,

Тав. Харилцан хүлээх үүрэг

5.1. Гэрээнд талууд харилцан хүндэтгэх зарчим дээр тулгуурлан хамтарч ажиллана

5.2. Гэрээний дагуу бичил уурхайгаар ашигт малтмал олборлох явцад байгаль орчин, бусад этгээдэд хохирол учруулсан тохиолдолд бичил уурхай эрхлэгч этгээд уг хохирлыг барагдуулах үүрэгтэй. Сум, дүүргийн Засаг дарга байгаль орчинд учруулсан хохирлыг арилгуулахыг бичил уурхай эрхлэгч этгээдээс ишаардана.

5.3. Нөхөн сэргээлтийн дундын санд байршуулсан барьцааны мөнгийг нөхөрлөлд бунаан олгохгүй бөгөөд нөхөн сэргээлтийг Алтай сумын "АЖ АРВИН ҮНДРАЛ" ТББ-ын төргүүн И.Баяржаргал бүрэн хариуцахаар тохиролцов.

5.4. Талууд энэхүү гэрээний биелэлтийг жил бүр хамtran дүгнэж, аймаг (нийслэл)-ийн Засаг даргад дараа оны 1 дүгээр сард баатан тайлagnana.

Зургаа. Маргаан шийдвэрлэх

6.1. Талууд гэрээтэй холбоотой үүссэн аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.

6.2. Талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шийдвэрлэнэ.

Долоо. Гэрээний хүчин төгөлдөр болох

7.1. Энэхүү гэрээ нь 20/8. оны 03 сарын 07 өдрөөс . . . 20/8 оны 06 сарын 07 өдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилиэ.

7.2. Энэхүү гэрээг Зхувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.

Найм. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

8.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцсоны
үндсэн дээр шийдвэрлэнэ.

8.2. Энэхүү гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь түүний нэгэн адил хүчинтэй
байх бөгөөд гэрээний салингүй хэсэг болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

АЛТАЙ СУМЫН ЗАСАГ

ДАРГА *Д.Доржийн* Д.ЦОРЭВСАМБУУ

УТАС: 99065252

АЛТАЙН БИЧИЛ УУРХАЙЧДЫН

ЭВ НЭГДЛИЙН ХОЛБООНЫ
ТЭРГҮҮН *Ч.Мяндагбадам* Ч. МЯДАГБАДАМ

УТАС: 89976063

Доржийн сан

НӨХӨРЛӨЛИЙН АХЛАГЧ

УТАСНЫ ДУГААР: *98486065*

З. Мяндагбадз
З.Мяндагбадз